

A brief introduction to the publisher agency | Upgrade 231231

Garuna Publishing

Read more Quality ...

...    @Garunapublishing ...

Khishgee .D

CO-FOUNDER / CORE DIRECTOR

BlueMon Tower, ~ 805, Floor #8,
J.SAMBUU STREET 32, SUKHBAATAR DISTRICT
ULAANBAATAR MONGOLIA.

Sansarkhuu .N

CO-FOUNDER / RESEARCH DIRECTOR

Phone number: +976-75117575, 99084979

Web address: www.garuna.mn

Munkhmend.B

CEO / CREATIVE DIRECTOR

E-mail address:

Official: Rights@garuna.mn

Simple: Contact@garuna.mn

Сайн байна уу,
Бид бол Garuna's CREW.

Бидний нэр бол - Манай агентлагийн соёлыг илэрхийлсэн томёолол ...

Бидний **ЗОРИЛГО** бол ...

Find Quality

Бидний **ҮНЭТ ЗҮЙЛ** бол ...

Print to Quality

Бидний **ЗОРИЛТ** бол ...

Quality to distribute

Бид чанарыг нэн тэргүүнд тавьж гэмээнэ оюуны соёлыг жинхэнэ утгаар нь эх орондоо түгээх болно.

Бидний **УРИА** бол ...

© **Creative** © **Create** © **Influence**

Nice to meet you 🥰

Our History



Khishgee.D
FOUNDER / CEO

Манай **ГАРУНА ПАБЛИШНГИЙН** агентлаг нь анх 5 жилийн өмнө буюу 2018 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Дэлхийн шилдэг ном, зохиол, бүтээл туурвилыг эх орондоо түгээх, Монгол оюуны соёл, уламжлалыг хойч үедээ өвлүүлэх, тэднийг өөртөө итгэлтэй, бие даасан оюунлаг, хүчирхэг хувь хүн болгон төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг.

ГАРУНА чанарыг олж, чанарыг хэвлэж, чанарыг түгээх үүднээс олон улсын жишиг болсон байгууллагуудтай харилцаа холбоо тогтоон ажиллаж байна.

Өнгөрсөн хугацаанд ФИЛОСОФИЙН, ХҮҮХДИЙН, ТАНИН МЭДЭХҮЙН хөтөч болохуйц ном бүтээлийг голлон гаргасан байна.

Бид +60 гаруй бүтээлийг маш амжилттай гаргасан ба туршлага хуримтлуулж буй баг хамт олон болж улам бүр хөгжиж суралцсаар байна.

Our Growth

2019

Best seller books

1. Бага насны (+1) хүүхдэд зориулсан зурагт АКО цуврал номыг гаргав / Series 1-6
2. Ад үзэгдэх зориг (Сүүлийн 5 жил шилдэг борлуулагчтай ном болов)
3. Жаргалтай болох зориг ном (Сүүлийн 5 жил шилдэг борлуулагчтай ном болов)



01

02



03



2020

Kid's books

Хүүхдийн номыг илүү түлхүү гаргасан жил байв.

1. Бүгд баадаг
2. Шүдний тухай ном / ХаХаХа
3. Түргэн тусламжийн хайрцаг
4. Сурагч болох бэлтгэл / Сургалтын ном
5. Зүрх сэтгэлийн дасгал / Сургалтын ном

2018

Garuna's Create

1. 2018 оны 09-р сард 5гишүүнтэй үүсгэн байгуулагдав
2. Монголын анхны баялаг агуулга бүхий хүүхдийн цуврал сэтгүүлийг гаргав / Series 1-6

2021

Philosophy's books

Блоггер, Орчуулагч ТОМё БОДё Гарунад нэгдэж оров.

1. Философи цагаан толгой
2. Математик филисофи бас бус
3. Философи Шинжлэх ухаан бас бус
4. Баруун тархи, Зүүн тархи
5. Нойр хулжаам хувьслын түүх



04

2022

knowledge books

Сэтгэлээ хайрлах ном / Өсвөр насны хүүхдэд зориулсан ном хэвлэгдэв +12
Өөрийгөө хайрлах ном / Өсвөр насны хүүхдэд зориулсан ном хэвлэгдэв +12
Улс төр эхлэн суралцагсад / Өсвөр насны хүүхдэд зориулсан ном хэвлэгдэв +12
0-3, 3-6 насны хүүхдийн чадварыг хэрхэн хөгжүүлэх вэ?

Нийгмийн хариуцлагын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сураг бичиг хэвлэгдэв
PHI-LOS-O-PHY Book event амжилттай зохион байгуулагдав

05



2023




Public books

1. Жолоодогч / Шинэ уран зохиолын ном
 2. Аз жаргал хүрэх ницшегийн сургаал / Философи
 3. Монголын шилдэг комик БУМБАРДАЙ хэвлэгдэв
 4. Мөнгө гэж юу вэ? Танин мэдэхүйн ном хэвлэгдэв
 5. Хатагтай Молли / Хүүхдийн зурагт ном хэвлэгдэв
- Хүүхдийн номын Book event амжилттай зохион байгуулагдав



06

WELCOME TO THE SPACE OF PHI-LOS-O-PHY BOOK EVENT



Философи

KID'S BOOK EVENT



Бумбардай


Олон улсын Манга Авардын 46 улсын 317 бүтээлээс шилдгийн шилдгээр шалгарсан комик цуврал Erdenebayar Nambaral-н зохиол "БУМБАРДАЙ" Хүүхдийн зурагт номын 8дах удаагийн хэвлэлтийг "ГАРУНА" паблишн албан ёсоор авч бяцхан уншигч нарынхаа гарт дахин хүргэж байна.



Children's SAVE for БАГВААХАЙ MAGAZINE

Япон улсад бага насны хүүхдийн боловсрол, боловсрол судлалын чиглэлээр төгссөн мэргэжилтнүүд эрхлэн гаргаж буй тус сэтгүүл нь хүүхдийн зөв дадал хэвшил, төлөвшлийн суурийг тавихад эергээр нөлөөлж, дэм болох зорилготой ба тус сэтгүүл бүрийг бүтээхдээ ном хэвлэлийн чиглэлээр туршлагатай япон мэргэжилтнүүд, хүүхдийн номын мэргэжлийн зураач, чадварлаг дизайнер, хүүхдийн зохиолч нартай хамтран ажилладаг болно.

Сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсролд зориулсан БАГВААХАЙ сэтгүүл нь хүүхдийн сурч мэдэх хүсэл эрмэлзлийг өдөөн хөгжүүлж, зөв дадал хэвшил, төлөвшлийн суурийг тавина. Түүнчлэн цуврал сэтгүүл бүр өөр өөрсдийн баялаг агуулгатай ба агуулга нь хуучрахгүй мөн дахин давтагдадгүйгээрэй онцлог.









+1 Kid's for A K O B O O K S S E R I E S

Ако Учияама зохиолч нь Японы Нагоя хотод төрсөн. Цэцэрлэгийн багш мэргэжилтэй. Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн бүтээсэн түүний олон зурагт номыг Японы зарим цэцэрлэгт сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглаж байна.


Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн зохиосон Ако багшийн номнуудын агуулга лнь зугаатай, мөн сургамжтай. Ако багш дүрүүдийнхээ нүүр царайг хачин жигтэй дүрсэлдэг нь хүүхдийн сонирхлыг маш их татдаг. Хөөрхөн зураг гэхээс илүүтэй "хүүхдийн нүдээр харж" зурсан өвөрмөц зураг нь уг цувралын гол онцлог юм.

Хүүхэдтэй харилцан ярилцангаа уншиж өгөөрэй. Хүүхдийнхээ 10 сайн талыг дурдаж, 10 удаа үнсээрэй.

-  Ганган мэлхий
-  Хаана байна, Хаана байна
-  Хонины ноосон утас
-  Хэнээс урам авдаг вэ?
-  Наашаа хаарай
-  Сахлын мухлаг



Books for E D U C A T I O N A L



ЗҮРХ СЭТГЭЛИЙН ДАСГАЛ

Хүүхэд бусадтай зохицон амьдрахад хэрэгтэй зан харилцаа, үйлдлийг өдөр тутмын ахуй амьдрал дунд эзэмшиж, талархах, энэрэх сэтгэлийг аажим аажмаар өөрийн болгодог. Эдгээр чанаруудыг нь улам хөгжүүлэх, шаардлагатай орчин нөхцөлийг бий болгох нь эцэг эхийн нэгэн чухал үүрэг юм. Бид энэ номонд хүүхдэд зөв буруугийн ялгааг таниулах, ёс суртахуунлаг чанарыг нь соёолж ургахад чухал сэдвүүдийг энгийн үг хэллэгтэй бичвэрээр илэрхийлж, сурах үйлийг улам хөгжилтэй болгох буддаг зургийн хамт орууллаа.



СУРАГЧ БОЛОХ БЭЛТГЭЛ

Монголд цэцэрлэгийн таван настнуудын ангийг “Бэлтгэл бүлэг” гэж нэрлэдэг. Энэ нэршил сурагч болох бэлтгэл таван настайгаас эхэлдэг гэх ойлголтыг багш, эцэг эхэд суулгаж байдаг. Угтаа сурагч болох бэлтгэл цэцэрлэгийн бага бүлгээс явагдах учиртай. Гэвч хүүхдийг сургуульд бэлдэх талаар монгол хэлээр бичигдсэн ном, материал ховор. Тиймээс бид Япон улсад цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн, арга зүйн ном дагнан хэвлэдэг CHILD группийн энэхүү гарын авлагыг орчуулан хүргэж байна.

Books for T E E N A G E R S



СЭТГЭЛЭЭ ХАЙРЛАХ НОМ

Зохиолч: Алис Жэймс, Луи Стовэл

Орчуулагч: Б.Сувддулам

Редактор: Д.Чимгээ

Дизайнер: Н.Сонинбаяр

Usborn publishing +12

ISBN: 9789919980030

Бид биеийн эрүүл мэнддээ байнга санаа тавьдаг хэр нь ээ бодол, мэдрэмж, сэтгэл зовнилдоо төдийлөн ач холбогдол өгдөггүй. Тэгвэл өсвөр насныханд зориулсан “Сэтгэлээ хайрлах ном” хэмээх эл гарын авлага нь мэдрэмж, түүнд нөлөөлдөг хүчин зүйлс, үерхэл нөхөрлөл, нийгмийн сүлжээ, дээрэлхэл, гэр бүл салалт, хагацал гуниг зэрэг олон сэдвийг хамарсан өргөн хүрээний мэдлэгийг олгоно.



ӨӨРИЙГӨӨ ХАЙРЛАХ НОМ

Зохиолч: Кэролайн Янг

Орчуулагч: Б.Сувддулам

Редактор: Д.Чимгээ


Дизайнер: Н.Сонинбаяр

Usborn publishing +12

ISBN: 978991980023

Энэ ном бол эрүүл амьдралын хөтөч. Үүгээр дамжуулж бид чамд амьдралд үл нийцэх, өртөг өндөртэй, элдэв гаж арга заахгүй, харин эрүүл амьдралын хэв маягтай болоход чинь туслах энгийн атлаа үр дүнтэй олон зуун аргыг хэлж өгнө. Мөн эрүүл, зохистой хооллох, өдөр бүр дасгал хөдөлгөөн хийх, унтаж амрах, стрессээ даван туулахтай холбоотой олон зөвлөмж ч бий.

Books for T E E N A G E R S



УЛС ТӨР ГЭЖ ЮУ ВЭ?

Зохиолч: Фрит, Хоре, Ствелл
Орчуулагч: П.Наранбаяр
Редактор: Ц.Батбаатар
Дизайнер: Д.Чимгээ
Usborn publishing +12
ISBN: 9789919957278

Бид уулзсан хүн бүртэй улс төр ярьж мэтгэлцээд байдаггүй. Учир нь улс төр бидний өдөр тутмын амьдралын ярианы сэдэв биш юм. Гэхдээ амьдарч буй нийгмээ ойлгоё гэвэл улс төрийн талаар мэдлэгтэй болох шаардлагатай. Улс төр бидний эргэн тойронд хаа сайгүй байдаг. Хүмүүс хот, улс орон, тивийг хэрхэн удирдах нь улс төр. Шийдвэр хаана гарч байна, тэнд улс төр байна. Дайн эхлэх, төгсөх нь ч мөн ялгаагүй улс төр юм.




МӨНГӨ ГЭЖ ЮУ ВЭ?

Зохиолч: Рэйнолдс, Олдхэм, Брайан
Орчуулагч: В.Ганзориг
Редактор: Н.Сансархүү
Дизайнер: Б.Мөнхмэнд
Usborn publishing +12
ISBN: 9789919980085

Банкны данс, орлого, зээлээс эхлээд засгийн газрын зарлага, татвар, инфляци зэрэг бүхий л зүйлийг багтаасан мөнгөний ертөнцийн талаарх мэдээлэл сайтай танилцуулга зурган хөтөч бүхий ном. Залуу уншигчдад мөнгө бидний амьдарч буй ертөнцийг яаж хэрхэн бүрдүүлдэг, хаанаас бий болдог, хэрхэн мөнгөтэй болох тухай маш энгийнээр бөгөөд хүртээмжтэй байдлаар тайлбарлаж ойлгуулах болно.

Books for P H I L O S O P H I C A L




ФИЛОСОФИ ЦАГААН ТОЛГОЙ

Зохиолч: ЯМЧА
Орчуулагч: ТОМё БОДё
Редактор: Ц.Батбаатар
Дизайнер: Т.Төгсжаргал
Futami shobo publishing
ISBN: 9789919980078

Философи анхлан суралцагч, суралцах гэж үзээд хэд хэд шантарсан хүмүүст зориулаад 30-аад философичийн танилцуулга маягийн хөнгөн уншигдахаар юм бичээд өгөөч Бичигчид ирсэн анхны хүсэлт нэг иймэрхүү юм байсан тул бичигч ингэж бодож байлаа...

“Дэлхийн хамгийн хүчирхэг үнэнийг мэдмээр байна уу?”
“Еэээээээээээээээээээээээээээээиийи”



МАТЕМАТИК ФИЛОСОФИ бас бус ...

Зохиолч: ЯМЧА
Орчуулагч: ТОМё БОДё
Редактор: Б.Болор-эрдэнэ
Дизайнер: Н.Бямбацогт
Futami shobo publishing
ISBN: 9789919957223

Математик ч бас бүлээн цустай, амьд биет! Математик хэмээх мэдлэгийн салбарын чинхүү гайхам гоо үзэсгэлэн, сэтгэл догдлом адал явдлыг ганц номонд багтааж баршгүй. Яагаад хүмүүс түүнд ховсдуулна вэ? Юуны төлөө амьдралаа өргөнө вэ? Уярал романс, өнгө мөнгө, амьдралын утга учир, хүний мөн чанар. Үүнийг танд математикаар дамжуулан хүүрнэх гэж энэ ном төрлөө. Алив, та сөхөөд нэг үз!


Books for P H I L O S O P H I C A L



ШИНЖЛЭХ УХААН ФИЛОСОФИ бас бус ..

Зохиолч: ЯМЧА
Орчуулагч: ТОМё БОДё
Редактор: Д.Чимгээ
Дизайнер: Б.Мөнхмэнд
Futami shobo publishing
ISBN: 9789919980061

Философи бол зөв гэж юуг хэлэх вэ гэсэн асуултыг тавьдаг мэдлэгийн салбар. Энэ ном нь шинжлэх ухаанлаг зөвүүдийн талаарх цочирдом сэдвүүдийг цуглуулж эмхэтгэсэн ном. Философийг мэдэхгүй жирийн хүмүүс ч сонирхон уншаад сонирхолтой гэж санагдахуйц сэдвүүдийг сонгон авч оруулсан. Хоолоор яривал философийн зөвхөн амттай хэсгүүдийг нь түүж аваад чанасан халуун тогоо гэж болно.




БАРУУН ТАРХИ, ЗҮҮН ТАРХИ

Зохиолч: Недожун
Орчуулагч: ТОМё БОДё
Редактор: Ц.Одонтуяа
Дизайнер: Б.Мөнхмэнд
Nedo Jun
ISBN: 9789919980092

Бодлоо арилгаж би гэх хайрцагнаасаа гарч ухамсрын шилжилт хиймээр байна, түүнийг биеэрээ мэдэрч туулмаар байна гэсэн хүмүүст зориулсан ном юм.

Баруун тархи бол хэн бүхний дотор орших бөөлөг ухамсар юм. Амьд байгалийн дуу хоолойг сонсож, эх газрын дуу хоолойг ч сонсоно. Харин зүүн тархи "Эх газрын хоолой энэ тэр сонсож суух зав алга аа! Цаг алдалгүй ажиллаж, цаг үетэйгээ зэрэгцэж явах минь!" гэж хэлнэ. Дэлхий ертөнц бүх эрчээрээ давхилдаж, хаашаа зүглэж явааг хэн ч үл мэднэ.


Books for P H I - L O S - O - P H I - C A L



ҮХЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Зохиолч: ШЕЛЛИ КАГАН
Орчуулагч: ТОМё БОДё
Редактор: Н.Өнөржаргал
Дизайнер: Б.Мөнхмэнд
Yale University
ISBN: 9789919247874

Үхэлтэй холбоотой ердийн ном бүтээлд лавтайяа нас барах процесс ч юм уу, таны сэтгэлзүйг үхэлд бэлдэх талаар нарийвчлан өгүүлдэг байх. Харин энэ номд тийм юм ярихгүй. Тэгвэл чухам юуны тухай ярих вэ? Энэ номд үхлийн мөн чанарын талаар эргэцүүлж эхлэх үед төрөн гардаг олон тооны философилог асуудлыг тойруулан ярилцана. Бид ингэхэд юу юм бэ? Хүн гэдэг ямар учиртай оршихуй юм бэ? Нэн ялангуяа, бидэнд сүнс гэж бий юу? Яриандаа орохоос өмнө шалавхан тайлбарлаад орхиход энэ номд "сүнс" гэдэг үгийг философилог утгаар ашиглаж, логик сэтгэлгээнд тулгуурлан авч үзэх болно. "Сүнс" гэдгээр би махан биеэс тусдаа биет бус (матери бус) зүйлийг илэрхийлнэ.



АЗ ЖАРГАЛД ХҮРЭХ ФИЛОСОФИ

Зохиолч: ЯМЧА
Орчуулагч: ТОМё БОДё
Редактор: Ц.Баттуяа
Хавтас: Э.Базаррагчаа
Аi зураг: Д.Төмөрхуяг
ISBN: 9789919980078

ТА бусдын мөрөөдөлтэй хөөцөлдөн, бусдыг даган хуйларч, бусдын хэмнэлээр амьдрах ёстой гэж? Юунд хүлэгдээд яваагаа өөрөө ч та мэдэхгүй байгаа биз? Тэгвэл таныг хаана ч байхгүй хялбархан бас хөгжилтэйгөөр НИЦШЕгийн өндөрлөгт хүргэж өгье! Учир нь одоо л нэг цаг үе Ницшег гүйцэж ирээд байна. Сонсох төдийд л хөндий оргидог маниак философи биш ээ. Толгой эргүүлсэн гүн гүнзгий академик онол ч биш. Өөр хэний ч бус чухам таны тухай ярьж, таны амьдралыг хүүрнэж, таны зовлонг илчилье. Алдарт "Ад үзэгдэх зориг" номтой адилаар харилцан яриа хэлбэрээр багш сурагч хоёрын асуулт хариулт өрнөж, таныг тантай нүүрэлдүүлнэ.

B I O L O G Y




НОЙР ХУЛЖААМ ХУВЬСЛЫН ТҮҮХ

Зохиолч: Ичихаши Нориказү
Орчуулагч: ТОМё БОДё
Редактор: Б.Болор-эрдэнэ
Дизайнер: Т.Төгсжаргал
8. Kawade Shobō Shinsha., Ltd
ISBN: 9789919267308

Биологийн хувьслыг ойлгож чадвал, амьдрал дахь баргийн зовлон бэрхшээлүүд ихэнх нь төдийлөн сонин биш юм шиг санагдаж ирнэ. Энэ хорвоо хэнд ч падлийгүй зүйлсээр дүүрэн бялхаж байна. Бодоод үз дээ! Өнөөгийн хүмүүсийн зовлон гэвэл гол төлөв үхмээргүй байна, ажил хиймээргүй байна, мөнгөтэй болмоор байна, ад үзэгдмээргүй байна, хайрлуулж дурлуулмаар байна, бусдад атаархаж байна, новшийн нөхдүүд дургүй хүргээд байна, за нэг иймэрхүү л юмс байдаг шүү дээ. Эдгээр асуудлууд хүнийг зовоож шаналгаад байдаг нь бүгд хувьслаас болж буй юм

L I T E R A T U R E



Ж О Л О О Д О Г Ч

Зохиолч: ЯМЧА
Орчуулагч: ТОМё БОДё
Редактор: Н.Өнөржаргал
Дизайнер: Б.Мөнхмэнд
10. Discover 21, Inc
ISBN: 9789919998653

Та азтай хүн үү? Эсвэл азгүй хүн үү? "Ямар хүн нь ёндоорч, ямар хүн нь гомбоорч явдаг юм бол?" гээд бодлогоширч явсан удаа байхгүй биз? Үнэндээ хүн бүр эн тэнцүү азтай гэвэл та итгэх үү? Хүмүүс азтай, азгүйгээрээ ялгардаг бус ердөө л хурааж, хэрэглэж буйгаараа ялгардаг. Аз гэдэг бол гийж эсвэл харьдаг зүйл биш ээ. Яг л дэлгүүрийн поинт карт шиг цуглуулж бас зарцуулдаг эд. Аз шүүрдэг антеннаа л тултал нь дэлгээд явбал гудамжаар дүүрэн азын үр хийсэж яваа. Тэгвэл хэрхэн антеннаа дэлгэж, азын үр цуглуулах аргыг танд одоо зааж өгье.

Books for K I D ' S



АНХНЫ ТУСЛАМЖИЙН ХАЙРЦАГ

Зохиогч: Ямада Макото

Орчуулагч: Д.Чимгээ

Редактор: Н.Навчаа

Дизайнер: Ц.Гантөмөр

Fukuinkan Shoten Publishers Inc ©

ISBN: 9789919957261

Хүүхэд гадаа гэрт тоглоход гараа зүсэх, гараа хаалганд хавчуулах, зөгийд хатгуулах, гартаа өргөс оруулах, хамраас цус гарах зэрэг асуудал байнга л тохиолдож байдаг. Энэ номыг үзсэнээр ээж хүүхэд хоёулаа тиймэрхүү үед барьц алдалгүйгээр зөв арга хэмжээ авч сурна. Бид хамраас цус гарахад дээшээ хардаг даа. Гэтэл энэ номд үүнийг буруу гэжээ. Энэ маягаар анагаах ухаан талаас зөв зөвлөгөөг унших боломжтой. Хүүхдийн сонирхолд нийцэхүйц хялбар зурагтай, эмийн нэр зэргийг эс тооцвол ойлгомжтой товч тексттэй. Төгсгөлд нь эм, шархны боолт зэргийн тайлбар, ээж нарт зориулан нэмэлт мэдээлэл оруулжээ. Хүүхэд гэдэг маш сониуч. Бие нь хүртэл тэдэнд маш сонирхолтой, ер бусын санагдах нь ойлгомжтой.



ШҮДНИЙ ТУХАЙ НОМ / ХАХАХА

Зохиогч: Како Сатоши

Орчуулагч: Д.Чимгээ

Редактор: Ч.Гантөмөр

Дизайнер: Б.Мөнхмэнд

Fukuinkan Shoten Publishers Inc ©

ISBN: 9789919957254

“Бүгд хөгжилтэй инээж байхад олны дунд ганц хүүхэд уйлж байх юм. Аан, мэдлээ мэдлээ! Шүд чинь өвдөөд уйлж байгаа юм байна. Шүд өвдөхөд том хүмүүс хүртэл заримдаа уйлчихдаг. “Ингэж их өвдөх юм бол шүдээр яах юм, хэрэггүй” гэж бодож байна уу?” Энэхүү номонд шүдний үүрэг, шүдээ бат бөх байлгаж хамгаалахын тулд юу хийх хэрэгтэй тухай, яагаад шүд хорхойтдог тухай, шүдээ угаах ямар чухал болохыг хүүхдэд тун ойлгомжтой тайлбарладаг. Хуудас бүрийн төгсгөлд асуулт, дараагийн хуудсанд хариулт гарч ирнэ. Японд лонгселлер болж, дэлхийн олон хэлэнд орчуулагдсан алдартай зурагт ном ийнхүү монгол хүүхдүүдийн гар дээр ирлээ. Айл бүрт, цэцэрлэг бүрт байх ёстой ном.

Books for K I D ' S



БҮГД БААДАГ

Зохиогч: Гомитаро

Орчуулагч: Д.Чимгээ

Редактор: Д.Чимгээ

Дизайнер: Б.Мөнхмэнд

Fukuinkan Shoten Publishers Inc ©

ISBN: 9789919957247

“Бүгд баадаг” буюу “Everyone roops” нэртэй энэ зурагт ном анх 1977 онд Японд хэвлэгдсэн. Япондоо 1 саяас их хувь зарагдсан лонгсэллер бөгөөд Америк, Англи, Хятад, Солонгос, Испани, Тайланд зэрэг дэлхийн олон оронд хэвлэгдсэн. “Том заан том баадаг, жижиг заан жижиг баадаг” гэж эхлээд амьтдын баасны талаар тун хөгжилтэй дүрсэлдэг. Амьтдын баас янз бүрийн өнгө, хэлбэр, үнэртэй тухай, амьтад хэрхэн баадаг, хаана баадаг, баачихаад баасаа яадаг талаар хүртэл гардаг. Амьтадтай зэрэгцээд мэдээж хүн ч мөн гарна. Том хүн, жаахан хүүхэд бүгд баадаг. Амьтад иддэг учраас бүгд баадаг... Амьтан хүн ялгаагүй. Байгалийн энгийн энэ хуулийг хүүхдэд хөгжилтэйгөөр заах зурагт ном.



ХАТАГТАЙ МОЛЛИГИЙН СУРГУУЛЬ

Зохиолч: Занна Дэвидсон, Рози рийв

Орчуулагч: Б.Сувддулам

Редактор: Д.Чимгээ

Дизайнер: Д.Чимгээ

Usborn publishing ©

ISBN: 9789919998677

Мисс Моллигийн эелдэг байдлын сургуульд гурван дэггүй үнэгний бамбарууш бусдад хэрхэн эелдэг байх, өөрсөддөө бас хэрхэн эелдэг байх, мөн эх дэлхийдээ эелдэг байхын чухлыг олж мэдэх туай энэхүү номонд өгүүлнэ.. Хүүхдүүдтэй эелдэг найрсаг, инээдэмтэй, хөгжилтэй түүх, амьд амьтдын дүрүүдийн тухай яриа өрнүүлэх төгс арга яах аргагүй энэхүү ном хэмээн бодож эрхлэн гаргасан болно. :)

Books for P A R E N T ' S



0-3 НАСНЫ ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ХЭРХЭН ХӨГЖҮҮЛЭХ ВЭ?

Зохиогч: Тошиюүки Шиоми

Орчуулагч: Ц.Онон

Редактор: Ц.Дэлгэрмаа

Дизайнер: Д.Чимгээ

Usborn publishing ©

ISBN: 9789919980047

Энэхүү номд ээж, аавууд гэр бүлээ хэрхэн цогцлоох, хүүхэд хэмээх тусгаар хүнийг харах, үйл хөдлөлийг нь ойлгох, хүмүүжлийн суурийг хэрхэн тавьж, ямар дүрэм журам баримтлах гэхчлэн хүүхэд өсгөн хүмүүжүүлэхэд зайлшгүй анхаарах ёстой зүйлсийг тусгаснаас гадна энэхүү үйл явц дахь сонирхолтой талыг хүүхдийн нас насны онцлогоор бүлэглэн бичлээ.

Мөнхүү, “Хүүхэд өсгөх гэдэг нь өөрийгөө ч мөн өсгөн хүмүүжүүлэх үйл явц юм” гэдгийг номоос маань олж мэдээсэй хэмээн хүснэ.



3-6 НАСНЫ ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ХЭРХЭН ХӨГЖҮҮЛЭХ ВЭ?

Зохиолч: Тошиюүки Шиоми

Орчуулагч: Ц.Онон

Редактор: Ц.Дэлгэрмаа

Дизайнер: Д.Чимгээ

Usborn publishing ©

ISBN: 9789919980054

Хүн амьралынхаа турш энэхүү үеэ оюун санаандаа хамгийн тод дурсамж болгон санаж үлдээж байдаг. Тийм ч учраас энэхүү цаг үеийн дурсамжаар дүүрэн өнгөрүүлэх ёстой. Нийгмийн амьдрал эхэлж, гэр бүлийн гишүүнээс нийгмийн нэгэн гишүүн болох шинэ үүд хаалга нээгдэж байгаа энэ үед эцэг эхийн оролцоо, эцэг эх, хүүхдийн хүн холбоо маш чухал. Энэхүү номонд маш олон бодит кэйс түүх дээр үндэслэсэн 3-6 настайдаа хүүхдийн анхаарах ёстой 10 энгийн дүрмийг санал болгож байгаа. Эцэг эх, асран хамгаалагч нар бүгд хүүхдээ бага сургуульд орохын өмнө санаа зовоосон хичээл, найз нөхөд, багш гэх мэтчилэн нийгмийн амьдралд хэрхэн харьцах талаар зохиолч маш өвөрмөц өнцгөөс тайлбарлах болно.

Books for K I D ' S



ХУРДАН ШАРГЫН ҮЛГЭР

Зохиогч: И.Ганбаатар
Дизайнер: Б.Мөнхмэнд
Редактор: Д.Хишгээ
Зураач: Б.Болормаа
Inner asia It'd ©
ISBN: 9789919998684

Дэлхийн олон үндэстний дотроос монголчууд шиг тийм үлгэрч ард түмэн тэгтэл олонгүй гэхэд хилсдэхгүй. Ярьсан үлгэр домог нь ам дамжин яригдсаар өдгөө ном болон хэвлэгджээ.

Хүүхдийн зурагт номын ертөнцөд зориулсан Дулаахан мэдрэмж төрүүлэх Монгол агуулга бүхий ном. +3

Залуудаа хурдан шарга нэрээрээ алдартай байсан өтөлж яваа шарга хүлгийн тухай өгүүлнэ. Хурдан шарга залуу хүлгүүдтэй уралдаах өөрөө өөрийгөө сойж бэлдэх ба түүнд туслахаар буян хүү, хүүгийн өвөө хоёр ихэд хичээх болно.




ХУДАЛДАЖ АВСАН ЗҮҮД

Зохиолч: И.Ганбаатар
Дизайнер: Б.Мөнхмэнд
Редактор: Д.Хишгээ
Зураач: Б.Болормаа
Inner asia It'd ©
ISBN: 9789919998691

Төв азийн ихэнх орнуудад түгэн дэлгэрч ам дамжин яригдаж ирсэн цэцэн цэлмэг, ховдог шунахай, овтой мэхтэй, бардам дээрэнгүй хүний хэлээр хөөрөлддөг элдэв төрлийн амьтад, нусгай бор хүү, хамуутай бор даага, гэр нэвт гэрэлтэгч үзэсгэлэнт охин, жигүүрт хүлэг морь, нар халхлан нэлийгч хангарьд, арван таван толгойтой атгаалжин хар мангас, цог шиг улаан нүдтэй махчин, уул гэж эндүүрмээр урт эрээн могой зэрэг зүсэн зүйлийн хорвоо дэлхийд оршдог, эс оршдог баатрууд гарч эхэндээ ч үйл явдал нь ээдэрч ирснээ, эцэстээ голдуу л сайн сайхан тал нь дийлж байдаг урт богино маш олон үлгэр домог байдаг билээ. Түүний нэгэн хэсэг болох уг үлгэрийг хүүхэд багачуудыг уншиж, чөлөөт сэтгэлгээ нь хязгааргүй тэлэх болтугай хэмээн манай хэвлэлийн газрын зүгээс эрхлэн гаргаж бэлэг барьж байна.

Бумбардагуй



Next book C O M I N G S O O N . . . J A N U A R Y



АЛДАГДСАН ХЭЛТЭРХИЙ ТОМ О-ТОЙ УУЛЗСАН НЬ ...

Зохиолч: Шел Силверстайн

Орчуулагч: Б.Оюундэлгэр

Редактор: М.Уянсүх

Дизайнер: Б.Мөнхмэнд

HarperCollins publishing


ISBN: 978-9919-9077-0-9

Published 2024.01.30

Philosophy of life BOOK - Энгийн атлаа хүчтэй дархлаажуулалтын вакцин+допин ... Амьдралын философийн тухай ганцаардсан хэлтэрхийгээр төлөөлүүлэн хүүрнэн өгүүлнэ. Хэрхэн амжилтад хүрэх бус хэрхэн хэцүү бэрхийг, хэрхэн уйтгар гунигийг, хэрхэн шантралыг, хэрхэн амжилтгүй болсон үед хариу үйлдэл үзүүлэхийг, бүтэлгүйтлийг хэрхэн даван туулах, алдаанаасаа суралцахын чухлыг заах бүх насныханд зориулсан гайхалтай БОДРОЛ бүтээл юм.

* Гээгдсэн хэлтэрхий ганцаар хэвтэнэ

** Хаашаа ч юм хажуудаа наагаад хамт явах нэгнийг хүлээнэ...



НИЙГМИЙН ДААТГАЛ ГЭЖ ЯГ ЮУ ВЭ?

Зохиолч: Don smith

Орчуулагч:

Редактор:

Дизайнер: Б.Мөнхмэнд

Arlington House Co.,ltd

ISBN: 1649706499


Published 2024.01.30

Энэхүү ном Нийгмийн хамгааллын маргаантай холбоотой сэдвийг хөндөх болно. Үнэхээр нийгмээ хамгаалж чадаж байна уу, эсвэл улс төрийн санхүүжилт болсон уу, та юу гэж бодож байна? Яагаад улс төрчид энэ талаар үнэнийг ярихыг хүсдэггүй вэ?

Гэхдээ бид энэ талаар ярихгүй бол нийгмийн даатгалын систем хэрхэн буруу ажиллаж байгааг хэзээ ч ойлгож чадахгүй өнгөрөх болно.


21-р зууны нийгмийн хамгааллын тогтолцоог өөрчлөх ТОМООХОН шинэчлэлийн цаг нь болсон учир энэхүү сэдвийг чухалчлан хөндөх болов.

BAGVAAKHAI book COMING SOON... FEBRUARY




БЭТГЭЛЖИН БОР ШУВУУ

Бяцхан шувуухай уут будаагаа унагачхаж гэнэ. Будаагаа эргүүлж авахын тулд олон хүн амьтанд туслах хэрэгтэй болжээ. Бусдад зориулсан тусын хариу заавал эргэж ирдгийг энэ номоос ойлгох болно оо.



БРЕМЕНИЙ ХӨГЖИМЧИД

Гриммийн үлгэрийн цоморлигоос 'Бремений хөгжимчид' хэмээх үлгэрийг бяцхан уншигчдадаа зурагт ном болгон толилуулж байна. Энэ үлгэр нь Германд төдийгүй дэлхий дахинаа алдартай бөгөөд гол баатар болох дөрвөн амьтны хөшөө олон оронд байдаг.



12 ЖИЛ ҮҮССЭН ТҮҮХ

Үлгэр хүүхдийн сэтгэл санааг маш ихээр хөөргөн баясгаж, тархийг нь бүрэн гүйцэд амрааж чаддаг. Мөн үгийн баялгийг нэмж, ухааныг үргэлж тэлж өгнө. Ялангуяа монгол үлгэрүүд элдэв бэрхшээлээс дандаа ухаан сийлжгарсан байдаг учраас сэтгэх чадвар хөгжихөд томоохон түлхэц болж чадна



ДУЛААХАН БЭЭЛИЙ

Өвлийн хүйтэн өдөр, нэгэн өвгөн бяцхан гөлгөө дагуулаад цасаар хучигдсан ойд иржээ. Тэрээр түлшээ бэлдэн явж байгаад өрөөсөн бээлийгээ гээснээ мэдсэнгүй.

Хаягдаж хоцорсон бээлий рүү хулгана гүйж ирээд бувтнав гэнэ.

Books for E D U C A T I O N A L



МААМУУ ХААНААС ИРДЭГ ВЭ?

Аав ээж нар хүүхдийнхээ насны онцлогт нь тохируулсан бэлгийн боловсролын талаар ярилцаж, зөвлөгөө өгөх нь хамгийн чухал үүрэг хариуцлага гэж хэлж болох юм. Бид ярилцаагүй, бодит мэдээ мэдээллийг зөв цагт нь өгөөгүйн улмаас хүүхдүүд маань санаатай болон санаандгүй алдаа гаргах нь цөөнгүй байдаг. Тэгвэл бэлгийн боловсрол гэдгийг бага наснаас авхуулан хүүхэд бүрийн насны онцлогт тохируулан хүний бие махбод болон түүний үйл ажиллагаа, нөхөн үржихүй, сэтгэл хөдлөл, хүний эрхийн талаар олгогдох цогц мэдлэг гэж ойлгож болно.



СОНИРХОЛТОЙ ТУРШИЛТЫН ЛАБОРАТОРИ


Таны хүүхэд Шинжлэх ухаанд дуртай юу? Япон хүмүүс хүүхэд ямарваа нэгэн хичээлийг ямар нэгэн хэмжээнд заавал туршиж үзэх ёстой, тэгж байж ойлгодог гэж үздэг. Тэхлээр зөвхөн онол талаас нь заах нь хүүхэд хичээлээ ойлгох нь бус бүүр сонирхолгүй болгох талтай байх нь ... Энэ ч үүднээс бид бага ангийн бяцхан сурагчдадаа зориулсан текст багатай, зурган байдлаар практик талаас нь гар доорх энгийн материал ашиглан туршиж үзэх шинжлэх ухааны туршилтын номыг Япон хэлнээс орчуулан гаргахад бэлэн болоод байна.

Books for SELF - DEVELOPMENT



АЗ ЖАРГАЛЫН ДЭГЛЭМ


Зохиогч Доктор Марта Бек нь Нью Йорк Таймс сонины шилдэг зохиолч, амьдралын дасгалжуулагч, илтгэгч гэдгээрээ олонд танигдсан. Амьдралаа илүү их баяр баясгалантай болгохыг хүссэн хүн бүрд зориулагдсан энэхүү номыг 2003 онд хэвлэгдэж байсан энэхүү ном нь өнөөдөр ч бэст селлер хэвээрээ байна. Аз жаргалын дэглэм нэртэй ном нь хөтөч байдлаар бичигдсэн ба уншсан хүн бүрийн ширээний ном болно гэдэг итгэлтэй байна.



УРАН БҮТЭЭЛЧ БОЛОХ ЗАМНАЛ

Хүн бүр уран бүтээлч болж чадах уу гэвэл тийм, үгүй гэж хэлнэ. Энэ нь тухайн хүний оюуны потенциалын цар хүрээ гэхээсээ илүү амьдралдаа хэрэгжүүлж буй арга барилаас ихээхэн шалтгаална. Уран бүтээлч болохыг зорьсон хүн бүрийн гарын авлага, хөтөч нь байсаар ирсэн төдийгүй бидний мэдэх маш олон алдартай уран бүтээлчдийн ширээний ном болж чаджээ. Өөрийгөө хэрхэн идэвхжүүлэх, бүтээлч зан чанараа (онгод) хэрхэн хөглөх, юунаас эрч хүчийг авах, блок түгжээнээс хэрхэн гарах, саад бэрхшээлийг хэрхэн даван туулах, амжилтыг зөөлөн хүлээж авах гэх мэт маш өргөн олон төрлийн агуулгыг багтаасан сорилт бүхий гарын авлаг, хөтөч ном юм.

Books for P H I L O S O P H Y




Зохиолч: КУСАНАГИ РЮШҮН
Орчуулагч: ТОМӨ БОДӨ
Редактор: Болушка
Дизайнер: Ч.Батбаяр
Publisher: Гарүна хэвлэлийн газар
Copyright: KADOKAWA, INC. Ryushun Kusanagi
ISBN: +978-9919-9077-9-0
Хуудас: 245 нүүр
Өнгө: СМҮК | 4+4 өнгийн өнгөт
Хавтас: Хатуу, 105гр экстра вайт | Эко
Дотор цаас: 105гр экстра вайт | Эко
Хэмжээ: 115мм*180мм

ХАРИУ ҮЙЛДЭХГҮЙ ДАДАЛ

Буддын эртний судар бичгийг судалж, ямар ч урсгалд харьяалагдахгүйгээр ажилладаг ламын бичсэн Буддын шашны хосгүй ном билээ. Зохиогчийн хэлснээр Буддагийн сэтгэлгээ нь аливаа зүйлийг оновчтойгоор ойлгож, аливааг эргэцүүлэн бодож, асуудлыг тодорхой арга зүйгээр шийдвэрлэх байдлаар номлодог.

Товчхондоо буддагийн сургаалаар өөртөө туслах ном гэхээсээ илүү тархи хэрхэн хариу үйлдэл үзүүлдэг тухай өгүүлдэг. Бие махбодийн механизм, хариу үйлдлийг физик талаас нь тайлбарласан тул философийн номтой төстэй байж магадгүй юм. Өөрөөр хэлбэр хувь хүний оршихуйн асуудлыг философи талаас нь өгүүлсэн ч гэж хэлж болно. Энийг зөвхөн уншигч л дүгнэх ёстой. Гүн ухааны ном учир анх уншиж байгаа хүн зохиолчийн зорилго, агуулга, хэлэх гэсэн санааг бүрэн гүйцэт ойлгохын тулд ихээхэн цаг хугацаа шаардана.

Thank you ❤️
For your attention



BlueMon Tower, ~ 805, Floor #08
J.SAMBUU STREET 32, SUKHBAATAR DISTRICT
ULAANBAATAR MONGOLIA.
+976-75117575, 99084979

www.garuna.mn